

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН  
ХҮНИЙ НӨӨЦИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

2025 оны 06 дугаар сарын 26

Багануур дүүрэг

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ХК нь Хүний нөөцийн стратеги төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх журам боловсруулан, хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч ажиллаж байна.

Хүний нөөцийн ил тод байдлыг хангах хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн болно.  
Үүнд:

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 37 дугаартай тогтоолоор Хувьцаат компани болон хэлбэр өөрчлөгдөж, бүтэц, орон тоо, албан хаагчдын бүрэлдэхүүн шинэчлэгдсэн.

Шинээр албан тушаал, сонгон шалгаруулалтын шаардлага хангасан 11 иргэн ажилд авч, ажлын байранд томилогдсон ажилтнууд Компанийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 02 дугаар сарын 18-ны А/08 дугаар тушаалаар батлагдсан Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Сул орон тоон дээр нөхөн бүрдүүлэлт хийж, 14 хүний бүрэлдэхүүнтэй (Магистр-5, Бакалавр-9, үүнээс Инженер 7, Хүмүүнлэгийн ухааны чиглэлийн мэргэжилтэй 7 ажилтан) ажиллаж байна.

Хүний нөөцийн холбогдолтой мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудас (baganuur-itp.mn)-т болон “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” фэйсбүүк хуудсанд тус тус байршуулж байна. Үүнд:

1. Ажилтан сонгон шалгаруулах зар,
2. Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний мэдээ,
3. Ажилтны ажлын гүйцэтгэл дүгнэх журам (Компанийн журмыг шинэчлэн боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 100 дугаар тушаалын 10 дугаар хавсралтын дагуу үнэлгээг хийж байна.)
4. Албан хаагчийн ёс зүйн дүрэм (Компанийн Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх захирлын А/09 дугаараар шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.)
5. Байгууллагад иргэд, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл хүсэлтийн мэдээг тус тус байршуулсан.

Албан хаагчад Төрийн албан хаагчийн ёс зүй сэдвээр сургалт бэлтгэн албан хаагчдад явуулж, сургалтын дараах асуумж, судалгаа авахад албан хаагчдын шинээр авсан мэдээ мэдээллийн хүртээмж, үр дүн 98 хувьтай үнэлэгдсэн.

Ажилтан сонгон шалгаруулах зарын дагуу Компанид ажилд орох хүсэлтээ ирүүлсэн иргэдийн мэдээллийг хүлээн авч танилцан, эхний шатны шаардлага хангасан иргэдтэй ярилцлага хийх журмаар ажилд сонгон шалгаруулж авч байна. Шаардлага хангасан ч тохиромжтой орон тоо байхгүй нөхцөлд Компанийн хүний нөөцийн бүртгэлд авч, энэ талаар өргөдөл гаргагчдад мэдээлэл хүргэсэн.

Мэдээллийн нээлттэй ил тод, хүртээмжтэй байдлыг хангах үүднээс Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг дараах хэрэгслүүдийг ашиглан байршуулж хүргэсэн.

- Компанийн албан ёсны веб сайт

- Компанийн албан ёсны пэйж хуудас
  - 24tsag.mn
  - Ulaanbaatar.mn
  - Livetv.mn
- Өдрийн сонин

Компанийн захиргаанд иргэд, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст улирал бүр гарган хүргүүлж, тайлагнаж байна.

МЭДЭЭ ГАРГАСАН:  
ГАДААД ХАРИЛЦАА, ХҮНИЙ  
НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН



М.МӨНХДУЛАМ